



# ИРГЭНИЙ ЗОРИГ НАМ CITIZENS WILL PARTY

2008 он 05 сар 18 өдөр

№

Улаанбаатар хот

## ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 08...

Сонгуулийн мөрийн хөтөлбөр  
батлах тухай

**Үндэсний Хорооны гишүүд, тооллогын комиссын дүнг үндэслэн  
ТОГТООХ НЬ:**

2008 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Иргэний Зориг Намын  
сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧИД

ИРГЭНИЙ ЗОРИГ  
НАМ

ТТА № 2102

.....		<i>М. Санхуйр</i>	
.....		<i>З. Маргалица</i>	
.....		<i>М. Чойдж</i>	
.....			
.....			



Иргэний Зориг Намын Үндэсний Хорооны гишүүдийн  
2008 оны 5 дугаар сарын 18 – ны өдрийн хурлын ..08  
дугаар тогтоолын хавсралт

### ИРГЭНИЙ ЗОРИГ НАМ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын хөгжил дэвшил, монголчуудын сайн сайхан амьдралын төлөө зориг шулуудан эвлэлдэн нэгдсэн Иргэний Зориг Намын гишүүд бид:

- Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нийт үндэстнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдлэх,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, ард түмнийхээ эв нэгдлийг бататган бэхжүүлэх,
- ардчилал, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог хөгжүүлж хуулийн өмнө хүн бүр адил тэгш байх,
- уламжлал - шинэчлэлийг зохистой хослуулах, аливаа туйлшралыг үл тэвчих,
- зөвшилцөх, ойлголцох, харилцан биесээ хүндэтгэх зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон дараах зорилтыг дэвшүүлж байна:

#### Нэг. Иргэдийн эрх, эрх чөлөө

Монгол орны хөгжил цэцэглэл юуны өмнө иргэдийнх нь эрх чөлөө, аз жаргалтай амьдралаас хамаарах тул төрийн бодлого нь иргэд өөрсдийн хүсэл зоригийн дагуу амьдралаа зохицуулах үндсийг бүрдүүлэхэд оршино. Иргэд төрийн хүнд сурталд хязгаарлагдахгүйгээр хувийн санаачлага, бүтээмжинд тулгуурлан амьдрах сайн цаг ирнэ. Үүний тулд:

- Монгол Улс оршин тогтнох уг үндэс болсон монгол хүнийг хүндэтгэн дээдлэх,
- Шударга бус явдал, авилга, хээл хахуулиас болж алдагдаж буй монгол хүний эх оронч, үндэсний үзэл, хүнлэг чанар, хүмүүжлийг иргэдэд төлөвшүүлэх ажилд төр засаг, иргэний нийгмийн анхаарлыг хандуулах,
- Амьдралдаа хариуцлагатай ханддаг иргэдтэй улс болохын тулд юуны өмнө хувийн өмчийг баталгаажуулж, тууштай хамгаалах бодлого баримтлах,
- Насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүд, хүний эрхийн зөрчлөөс үүдэж буй монгол хүний аюулгүй байдлын асуудлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах.

#### Хоёр. Улс төр, эрх зүй

Улс орныхоо эрх ашиг, эрх чөлөөт байдал, төрт ёсныхоо уламжлалыг эрхэмлэсэн, хуулийн ноёрхлыг нийгмийн харилцаанд жинхэнэ утгаар нь тогтоох, иргэдийн ажиллаж амьдрах эрхийг бодитойгоор ба талгаажуулах, тэдний аюулгүй байдлыг бүрэн хангах хүчтэй, шударга, чадварлаг төр-ийг бий болгож бэхжүүлэх нь бидний ойрын зорилт юм. Үүний тулд:

- Иутгийн удирдлагын эрх мэдлийг бодитойгоор хэрэгжүүлэх хууль зүйн орчин бүрдүүлэх,
- Аймаг, сум, нийслэлийн засаг даргыг ард иргэд шууд сонгодог болох,
- УИХ-ын сонгуулийг иропорциональ системээр явуулах хууль батлуулах,
- Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрхийг Үндсэн Хуулийн Цэцэд олгуулах,
- Авилга, төрийн албаны хүнд суртлыг арилгах,
- Засаг захиргааны орон тоо, зардлыг 30 хувиар багасгах,
- Шүүх, прокурор, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг ил тод, шударга болгох,
- Мэдээллийг хайх, олж авах болон мэдээллийг түгээх эрхийг хуулиар баталгаажуулах,
- Иргэдийн оролцоог дэмжиж, иргэний нийгмийг хөгжүүлэх.


### Гурав. Боловсрол

Дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ үзүүлдэг өндөр боловсрол, мэргэжил, мэргэшилтэй монгол хүнийг бид бэлтгэнэ:

- Суурь боловсролыг төрөөс онцгойлон анхаарч, багш бэлтгэх тогтолцоог сайжруулах,
- Нэг загварын хэвшмэл сургалтыг өөрчилж, ерөнхий боловсролын болон мэргэжлийн сургуулийг олон хэвшлийн, оролцооны аргад тулгуурласан сургалтад хандуулан, суралцагчдын чөлөөт сонголт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Багш нарын цалин хангамжийг эрс нэмэгдүүлэх,
- 18-28 насны залуусын боловсролыг дэмжих зорилгоор нэг удаа наян мянган төгрөгийн сургалтын тэтгэлэг олгох,
- Боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын чиглэлийг оновчтой болгох,
- Залуусыг тодорхой мэргэжил, мэргэшилд суралцах нөхцөл бололцоог бүрдүүлж, техник мэргэжлийн 15-аас дээш тооны сургууль шинээр байгуулах,
- Сурах хүсэл сонирхолтой, авъяаслаг хүүхэд залуучуудыг гадаад, дотоодын нарийн мэргэжлийн сургуульд суралцуулах бодлогыг тууштай баримталж 8000 залуусыг гадаадад сургана.
- Дэлхийн нэр хүнд бүхий их, дээд сургуулиудын салбарыг эх орондоо нээхийг дэмжиж өндөр түвшний боловсрол олох боломж бүрдүүлнэ.

### Дөрөв. Эдийн засаг, нийгмийн хамгаалал

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг эдийн засгийн галаар баталгаажуулах нь бидний гол зорилго болно. Нийгмийн салбарт баримтлах бодлогын төв нь эх орон, газар шороогоо гэсэн элгэн халуун сэтгэлтэй, шударга ёс, эрдэм оюун, ажил хөдөлмөрийг эрхэмлэн дээдлэгч монгол хүнийг төлөвшүүлэн хөгжүүлэх явдал бөгөөд улмаар ард түмний амьдралын түвшинг эрс дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ. Үүний тулд:




- Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өсөлтийг 10 хувиас доошгүй байлгах,
- Оюуны багтаамж ихтэй, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн олноор үйлдвэрлэх арга хэмжээ авах,
- Атрын III аян, цагаан, ногоон хувьсгалыг эрчимжүүлж бодит ажил болгох,
- Сумын иргэдэд үйлчилдэг 30 сая төгрөгийн Хөгжлийн сан байгуулах,
- Мал сүргийн үүлдэр угсааг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх,
- Сумдад мал, түүхий эдийн зах ажиллуулах,
- Хот, хөдөөд 248 мянган ажлын байр шинээр бий болгох,
- Эдийн засгийг нутаг дэвсгэрээр бүсчлэн хөгжүүлж, бүс нутагт иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх, хөдөөд чиглэсэн татвар, хөрөнгө оруулалт, зээлийн ялгавартай бодлогыг хэрэгжүүлэх. Төв, орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал бүрийн арга хэмжээ авна.
- Малчид, тариаланчид, жижиг дунд бизнес эрхлэгчид, бичил үйлдвэржилтийг мөнгө зээлээр дэмжих зорилгоор төв, орон нутагт зээлийн баталгааны 28 сан байгуулж ажиллуулах,
- Ажлын нэгж цагийн үнэлгээнд шилжих,
- Төрийн албан хаагчид, эмч, багш нарын сарын цалинг найман зуун мянган төгрөгт хүргэх,
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 280 мянган төгрөг, өндөр настны тэтгэврийн доод хэмжээг 180 мянган төгрөг болгох,
- Банк санхүүгийн найдвартай тогтолцоог бий болгож зээлийн хүүг бууруулах. Орон сууцны зориулалттай зээлийн жилийн хүүг 8 хувиас доош буулгаж, эргэн төлөгдөх хугацааг найман жилээр сунгаж хорин гурван жил болгох,
- Гадаадын зээл тусламжийг эдийн засгийн бодит салбарт, зээлийг ашиг орлогоороо эргүүлж төлөх чадвар бүхий объектод авахыг чухалчлах бөгөөд гадаадаас зээл авах эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүдийг хуульчлан тогтоох,
- Зах зээл дэх үнэ, тарифын өсөлтийг хязгаарлах бодлого хэрэгжүүлж инфляцийг найман хувиас доош байлгах,
- Монгол хүн бүрийг эх орных нь эрдэс баялагтай хүйн холбоотой болгож ашигт малтмалын олборлолтоос ноогдол ашиг авах хувьцаа олгох,
- Хот, хөдөөд дөрвөн жилд нийтдээ 48 мянган айлыг тохилог орон сууцанд оруулах, хотод наян км хурдны зам, гүүр барих.
- Нийслэл хотод метро байгуулах төслийг эхлүүлэх.

**Тав. Эрүүл мэнд**

Монгол төрийн оршин тогтнох үндэс нь монгол хүн гэсэн зарчмыг баримтлан ирд түмнийхээ эрүүл мэндийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх бөгөөд энэ үүднээс эрүүл мэндийн салбарт техникийн шинэчлэл хийх, эмнэлэгийн байгууллагын ажилтнуудын ажиллаж амьдрах орчин нөхцлийг сайжруулах, цалин хангамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна. Үүний тулд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний олон шатлал, чирэгдлийг багасгаж, чанар хүртээмжийг сайжруулах,
- Орчин үеийн техникээр тоноглогдсон найман эмнэлэг барьж үйлчилгээнд оруулах,
- Сум, өрхийн эмнэлгийн санхүүжилтийг хоёр дахин нэмэгдүүлэх,



- Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, төлбөрийн тогтолцоог шинэчлэн, өвчлөөгүй иргэдэд урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх,
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүн, ажлын хариуцлага, ёс зүйтэй нь холбох замаар эмч, ажилчдын орлогыг нэмэгдүүлэх,
- Эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгож иргэн бүрийг эмчилгээний төлбөрийн карттай (ваучер) болгоно,
- Эм тарилгын хангамжийг сайжруулж, чанарын хяналтыг хүчтэй болгох.

### Зургаа. Байгаль орчин


Үеийн үед байгаль дэлхийгээ шүтэн хамгаалж ирсэн монгол түмнийхээ уламжлал дээр тулгуурлан байгалиа хайрлан хамгаалах, үр шимийг нь эзэмшин хүртэх, үүний сацуу хойч үедээ өгөөж, үржил шимтэйгээр нь өвлүүлэн үлдээх учиртайг ухааран мэдэрсэн иргэдтэй, зохистой хэрэглээний шинэ соёл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн бодлоготой улс орон болоход бидний зорилго оршино. Үүний тулд:

- Дэлхий нийтээрээ даган мөрддөг стандарт, олон улсын гэрээ, конвенциудыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлдэг механизм бий болгох,
- Экологийн хүмүүжил, шинжлэх ухааны үндэслэлтэй орчин үеийн сургалт явуулах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн тухай мэдээллийг нээлттэй болгох,
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэн салбар хоорондын бодлого зохицуулалт, хяналтын механизмыг боловсронгуй болгох,
- Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилттэй тэмцэх үндэсний (экологи, нийгэм, эдийн засгийн) чадавхийг бий болгох,
- Байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг шинжлэх ухааны ололт амжилтыг үндэслэн иргэдэд удаан хугацаагаар тогтвортой ашиглуулах,
- Байгалийн баялагаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний эдийн засгийн салбарыг хөгжүүлэх,
- Улаанбаатар хот, суурин газрын утаа униар, агаарын бохирдлыг эрс бууруулах,
- Хот, суурин газар, гэр хорооллын хог хаягдалыг зайлуулах үр дүнтэй систем нэвтрүүлнэ.

### Долоо. Хүнс

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл аж төрж, хөдөлмөрлөх суурь нөхцөл болсон баталгаат хүнсээр хангах, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, чанартай хоол хүнс хэрэглэх, хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнээ эх орондоо үйлдвэрлэхийг бид зорино:

- Хүнсний хангамж, хүртээмж, хэрэглээ, тогтвортой байдлыг цогцоор нь хангах эрх зүйн орчин, салбар дундын зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх,
- Хүнсний баталгаат байдлыг хангахад төр, хувийн хэвшлийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох,




- Хоол хүнсний хэрэгцээнийхээ 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж хүнсний аюулгүй байдлыг найдвартай болгоно. Үүнд стратегийн хүнс – улаан буудай, гурил, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангах,
- Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх,
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээнд тулгуурлаж урьдчилсан хяналт тавих,
- Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, хүнсний аюулгүй байдлын хараат бус хяналтын лавлагаа лабораторийг байгуулах,
- Хөдөө аж ахуйн сурвалжтай хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох механизмыг бүрдүүлэх,
- Хүнсний бүтээгдэхүүний импортыг зөвхөн хуулийн этгээд гүйцэтгэдэг болох, экспортлогч улсын хүнс үйлдвэрлэгч компаниудын бараа бүтээгдэхүүнд системчилсэн хяналт тавих,
- Спирт, химийн хортой бодисын үйлдвэрлэл, нийлүүлэлтийг төрийн мэдэлд авч, хэрэглээнд тавих хяналтыг чангатгана.

#### Найм. Хүүхэд, залуучууд

Монгол Улс хүүхэд, залуучуудын орон. Хүн амын 70 гаруй хувь нь 35 хүртэлх насны залуучууд, 46 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байна. Иймээс манай ирээдүй болсон хүүхэд залуучуудын төлөө дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- Хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээг бий болгох,
- Хүүхэд хамгаалах тогтолцоог хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлтийг оруулах,
- Хүүхэд хамгааллын асуудлаар яам, агентлагийн хариуцах чиг үүрэг, уялдаа холбоог тодорхой болгох,
- Хүний эрхийн үндэсний комиссийн бүрэлдэхүүнд хүүхэд хамгааллын асуудал дагнаа хариуцсан гишүүнийг ажиллуулах,
- Хүүхэд хамгааллын олон нийтийн омбудсман – тай болох,
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуульд бэлтгэх олон хувилбартай үйлчилгээг бий болгох,
- Сайн ээжид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
- Хүүхэд, залуучуудын театр, спортын ордон, тоглоомын талбай, иарк, кино театрыг барьж байгуулах,
- 18-28 насны залуучуудад зориулж сурах, боловсрох, мэргэжил эзэмших, бие даан амьдрах нөхцлийг хангах цогц хөтөлбөр боловсруулах.

Монгол хүнээ дээдлэх  
Сайн цагийг бид авчирна



ИЗН